

XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ ТҮҮХЭНД ЭРДЭНЭ ЖИНОН ВАН Ц.ШИРНЭНДАМДИНГИЙН ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

МУИС, Нийгмийн ухааны
факультетын магистр
Н.Мөнхцэцэг

XX зууны эхэн үеийн Монголын улс төрийн амьдралд идэвхтэй оролцож Монгол улсынхаа бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, эв нэгдлийн төлөө санаа сэтгэлт Эрдэнэ Жинон ван Ц.Ширнэндамдин нь Бүрэн засагчийн 8-р он буюу Европын 1868 онд Түшээт хан аймгийн Дархан Чин вангийн хошууны гутгаар зэрэг тайж Цэрэндоржийн ахмад хөвгүүн болон мэндэлжээ. Эцэг Цэрэндорж нь гутгаар зэрэг тайж хүн. Түүний өвөг Д.Ринчендорж нь Манжийн хаанд тэрслэн босоод, өөрөө цаазлуулж, хөрөнгөө хураалгасан ажээ. 1688 оноос 200 өрх тэргүүлсэн хүнд гутгаар зэргийн тайж олгодог журмыг Манжийн засаг тогтоосон билээ.

Ширнэндамдин угаас язгууртан гэрт өсөн хүмүүжиж байсан бөгөөд бүр 8-9 настайгаасаа монгол, манж, хятад хэл бичгийг заалгаж зэгсэн сайн сурчээ /4,64/. 1889 оны үеэс Их Хүрээн дэх Манжийн амбан сайдын яамнаа сурах бичээчийн албыг хааж улмаар дадлага, туршлагатай түшмэл болжээ.

Чин улс нийгмийн гүнзгий хямралаасаа гарахын тулд 1901 оны эхээр "Шинэ засгийн бодлого" гэдэг шинэтгэлийг эзэн хаант төрийн хяналтаар орон даяар явуулж эхэлсэн. Энэхүү "Шинэ засгийн бодлого" гэгч нь шинж агуулгаараа Монгол үндэстний тусгаар тогтнолд нэн аюултай байсан учир монголчуудын эсэргүүцэлтэй тулгарч байв. Ийм нөхцөлд Ширнэндамдин 1908 оны үед Бээжинд Их Хүрээн дэх Манжийн амбан сайдын яамны газрын төлөөлөгч түшмэлээр ажиллах болсон байна. Энэхүү томилолт нь түүнийг тусгаар тогтнолын төлөөх тэмцлийг тууштай хэрэгжүүлэгч болоход нөлөөлсөн гэлтэй. Учир нь энэ үед Манж гүрэн улс орноо нуран унахаас хэрхэн хамгаалахаа мэдэхгүй болж, дотооддоо хямрал тэмцлээр дүүрэн болсон, хөгжлөөр хоцрогдсон, их гүрнүүдтэй адил бус гэрээ хэлэлцээ хийж буй зэрэг нь өөрийнх нь төрөлх оронд ямар ихээр нөлөөлж буйг хүний нутагт бөхөлзөн ажиллахдаа анзаарч мэдэрчээ.

Ийнхүү түүнийг Бээжинд ажиллаж байх хугацаанд Чин улсын дотор ялангуяа Хятад газар Үндсэн хуулийг даруй хүчин төгөлдөр болгох, улсын хурлыг ойрын жилд зарлан хуралдуулахыг шаардсан хөдөлгөөн хүчтэй өрнөсөн тул 1910 оны 10-р сард Бээжин хотод Засагт тус хийх яамны анхдугаар хуралдаан нээгджээ. Үүнд, мужуудын хэлэлцэх хорооны төлөөлөгчдөөс гадна эзэн хааны ордноо шууд томилон оролцуулсан хүмүүс тэн хагас нь байжээ. Ар, Өвөр Монголоос бүгд 10-аад хүн

хэлэлцэгч түшмэлээр уг хуралдаанд оролцсоны дотор Ар Монголоос Их Хүрээний монгол сайд Пунцагцэрэн, Сэцэн хан аймгийн ван Доржпалам, Жинон ван Ширнэндамдин нар оролцсон. Монголын төлөөлөгчид шинэ засгийн бодлогоор монгол газар хэрэгжүүлэх гэж байгаа бүх арга хэмжээ, нэн ялангуяа эдийн засгийн талаар төлөвлөж байсан зүйлийг эрс эсэргүүцэх чиглэлтэй байжээ. Энэхүү Шинэ засгийн бодлого гэгчийн уршиг хэр болохыг ойлгосон тэд Монголд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа арга хэмжээг айлтгал гуйлтаар болиулж чадахгүй гэдгийг ойлгосон учир гэдрэг буцахыг яаравчлах болон хуралд оролцохоос булзаарч үлдсэн юм.

Монголын үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцэгч эх орончид 1911.12.01-нд Манжийн сүүлчийн амбан Сань Дог өргөөнөөс нь хөөж, манж гарнизоны зэвсгийг хурааснаар Монголд 200 гаруй жил ноёрхсон Манж Чин улсын дарлалыг эцэс болгосон ба тусгай тунхаглал гаргаж Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээснийг зарлажээ.

Монгол улсын тусгаар тогтнол дахин сэргээснийг ийнхүү зарлан тунхагласан нь Манжийн эрхшээлийн үед сөрөг элитийн үүрэг гүйцэтгэж байсан Монголын ноёд язгууртнууд эрх баригч элитийн байр сууринаа шилжсэний илэрхийлэл болсон юм.

Энэ үйл явдлыг сэтгэл, зүтгэлээрээ талархан угтаж, өөрийн ухамсарт амьдралаа түүний төлөө зориулсан хүн бол Жинон ван Ширнэндамдин юм. Тэрбээр 1911 он буюу Хэвт ёсны 3 оны өвлийн сүүлч сарын 11-нд Монгол улсдаа хүчин зүтгэхээр эх нутагтаа иржээ. Ийнхүү хүрэлцэн ирэхэд нь Монгол улсын хаан Жибзундамбаас "...улс төрд хүчин зүтгэсэн тул Ширнэндамдинд зарлигаар хишиг тархаахад 2-р Богдын угсаад холбогдсон бусдаас ялгавартай тул үүнээс хишиг хүртээж /3/ үе улиран улсад туслагч гүн харавтар улаан жолоо шагнаан хүртээжээ"./5,17/

Мөн 3-р сард гавъяа байгуулсан зүйл бүхий тулд хэтэрхий хишиг хүртээж бэйсийн зэрэг шагнасан байна. /3/

Шинэ тулгар Монгол улсын засгийн газар юуны түрүүнд төв, орон нутгийн засаг захиргааны ажлыг сайжруулах болон улс орны амьдралыг хөтлөн явуулахад зохих мэдлэг чадвартай, үнэнч шударга, ажил хэрэгч, төр түшилцэх туршлага бүхий түшмэдийг сонгон шалгаруулж төрийн албанд зүтгүүлэх нь чухал юм гэж үзсэн. Төр түшилцэх түшмэлийг сонгон авахдаа уг хүний эрдэм чадал, сахилга бат, ажил хэргийн төлөв байдал, нас зэргийг голлох болзол болгосон нь Олноо Өргөгдсөн Монгол улсын үеийн өмнөх үеэс ялгагдах онцлог байсан юм. Тиймээс ч энэхүү шалгуурт Ширнэндамдин тохирч байсан нь эргэлзээгүй бөгөөд түүнийг Шүүх явдлын яамны дэд сайдын албанд тохоон томилжээ.

Олноо Өргөгдсөн Монгол улс дотооддоо төр засгаа төвхнүүлэн бэхжүүлэхийн хамт өөрийн тусгаар тогтнолыг бусад улс гүрнээр, юуны өмнө Хятад, Оросоор зөвшөөрүүлэх талаар чармайлт гарган ажиллаж байжээ.

Энэ үед Ширнэндамдин Шүүх яамны дэд сайд болоод удалгүй 1912 оны сүүл 1913 оны эхээр буюу 2 сар орчим хугацаагаар Монгол улсын гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамны тэргүүн сайд Эрдэнэ дайчин

Чин ван Ханддорж, гүн Цэрэндорж нарын хамт Хаант Орост айлчилсан юм. Тус албан ёсны айлчлалын зорилго нь Монгол улс тусгаар тогтнолоо бататган бэхжүүлэх, Монгол улсаас тусгаар байдлын илэрхийлэл элчин солилцох, мөн санхүүгийн болоод зэр зэвсгийн тусламж эрэх зэргээс гадна Петербург дэх гадаадын хэд хэдэн улсын элчин сайдтай учран хэлхээ холбоо тогтоох, улмаар Англи, Франц зэрэг орнуудаар очиж найрамдлын гэрээ байгуулах зорилгыг давхар агуулж байв.

Энэхүү айлчлалд албан ёсны эрх бүхий төлөөлөгчөөр явах болсон нь Ширнэндамдингийн хувьд Монголын тусгаар тогтнолын төлөө тууштай тэмцэгч, улс төрийн том лидер, гарамгай зүтгэлтэн чин ван Ханддоржоос суралцах төдийгүй хамтран ажиллах том завшаан болсон.

Тусгаар тогтнолоо тунхагласан Монгол улсын элч нарыг Хаант Орос улсын Гадаад, Цэрэг, Сангийн яамны сайд нар, Николай II хаан хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн боловч Оросын засгийн газраас Монголд хоёр сая рублийн мөнгөн зээл, хязгаарлагдмал хэмжээний зэвсэг олгох, Ховдын хязгаарыг Монголын бүрэлдэхүүнд оруулахыг зөвшөөрч бусад санал хүсэлтэд татгалзсан байна./6,15/

Петербург дэх гадаад орны элчин сайдын яамд, түүний дотор Японы элчин сайдын яам ч Монгол улсын анхны төрийн элч нарын айлчлалыг ихэд анхааран ажиглаж байсан нь лавтай.

Олноо Өргөгдсөн Монгол улсын засгийн газраас өөрийн улсын тусгаар тогтнолоо гадаадын томоохон гүрнүүдээр хүлээн зөвшөөрүүлэх асуудалд их гүрнүүдийн зүгээс хэрхэн хандаж байсан талаар доктор, профессор Л.Бат-Очир, С.Отгонжаргал нар "XX зууны Монгол дахь улс төрийн түүхэн үйл явц" номондоо: Богд хаант Монгол улсын Засгийн газраас сэргээн босгосон үндэсний тусгаар тогтнолоо дэлхийн томоохон гүрнүүдэд уламжлан улмаар дэлхий нийтээр хүлээн зөвшөөрүүлэх, тэдэнтэй найрсгаар харилцан хамтран ажиллах замаар тусгаар тогтнолоо бэхжүүлэх талаар тавьсан чармайлт, дээрх санал санаачилга, нэр бүхий улсууд хийгээд бусад улсуудын зүгээс, тухайлбал Дундад иргэн улс АНУ, Япон, Дани, Австри зэрэг улсуудын зүгээс маш тодорхой товтой хариу ирүүлсэн баримтыг бид одоо хараахан тогтоож чадаагүй байна.

Дундад иргэн улс дэлхийн бусад томоохон хийгээд жижиг буурай улсууд Монгол улсын тусгаар тогтнолыг албан ёсоор ноот бичиг солилцон батлан зөвшөөрөөгүй явдал нь тухайн үеийн дэлхий дахины олон улсын дундын байдал, дэлхий хийгээд дорно дахины хоцрогдсон орнууд үндэс угсааныхаа тусгаар тогтнолыг эрмэлзэх явдал идэвхжиж, байдал хүндрэх хандлагатай байсан хийгээд тэдгээр орнууд Дорно дахины "шинэ Хятад" улстай түнжин хагарах сонирхол хараахан бүрдээгүй, түүнийг аялдан талцах хандлага хүчтэй байсантай холбоотой болов уу. Гэхдээ Англи, Франц, Герман, Бельги, Голланд, ялангуяа Орос улс Монгол тусгаар тогтнолоо сэргээсэн явдалд "талархан нааштай хандаж" Монгол улсын тусгаар тогтнолыг бүрэн хийгээд хагас зөвшөөрөх" /7, т.14-15/ хандлагатай байсан нь Монголын төлөөлөгчдөд ихээхэн найдвар төрүүлж байлаа. Тиймээс ч Петербургт очсон хойноо Ханддорж, Ширнэндамдин нар засгийн газартаа ирүүлсэн нэгэн бичигтээ: "... Гадаад

айлчилсан
тогтнолоо
йлэл элчин
ргээс гадна
ран хэлхээ
айрамдлын
болсон нь
өө тууштай
нддоржоос

рыг Хаант
ай II хаан
с Монголд
всэг олгох,
өөрч бусад
отор Японы
айлчлалыг

ийн улсын
вшөөрүүлэх
ар доктор,
ол дахь улс
ын Засгийн
н томоохон
шөөрүүлэх,
огтнолоо
нэр бүхий
улс АНУ,
втой хариу

жиг буурай
оот бичиг
ий дахины
хоцрогдсон
идэвхжиж,
рно дахины
бүрдээгүй,
й болов уу.
Орос улс
сай хандаж"
рөх" /7,т,14-
эн найдвар
Ханддорж,
:"... Гадаад

яамны тэргүүн сайд Эрдэнэ дайчин чин ван Ха, шүүх яамны дэд сайд бэйс Ши нар нэр хамт айлтгасан нь ... мөнөөхөн манай Монгол нийт бүхнээр Чин улсаас салаад өөртөө тогтнож өөрөө эзэрхэг улс төр байгуулсан зэрэг явдлыг олон гадаад улсад мэдтүгэй хэмээн зарласанд их Орос улсын хаан эзний засгийн газраас бүрэн эрх барих сайдыг тусгайлан гаргаж манай Нийслэл Хүрээнд ирүүлэн найрамдлын гэрээ бичиг хэлэлцэн тогтсон ... хянаваас Орос улсын засгийн газраас шавь боолчуудыг хүрсэн цагт өөр зүйлийн хэрэг хэлэлцэж гэрээ бичиг байгуулсугай хэмээх буюу эсхүл тэнд суугаа бусад олон улсын элчин сайдууд бидний улс лугаа найрамдлын гэрээ бичиг байгуулан худалдаа нэвтрүүлсүгэй хэмээх нь буй аваас хэрхвээс зохих, хэрэв хэрэг хэлэлцэн гэрээ бичиг байгуулах зүйл буй болбаас хэрэг бүр тухайд үзэж зарлигийг гуйн айлтгаж хичээнгүйлэн дагаж шийтгэмүү... 2-р он өвлийн дунд сарын 15" /1,Ф-А-2,Т-1,Хн-5,т-271-275/ гэжээ.

Монгол улсын засгийн газраас өөрийн улсын тусгаар тогтнолд нааштай хандаж болох тухайлбал Япон улс засгийн газраа мөн элчингээ илгээх асуудалд давхар анхаарч байсан билээ. Ханддорж, Ширнэндамдин нарыг Петербургт байсан тэр үед 1912 оны өвлийн сүүл сарын 11-нд Бүгд ерөнхийлөн захирах сайдын яамнаас Петербургт илгээсэн нэгэн цахилгаан мэдээнд "манай засгийн газраас Япон улсын засгийн газраа Дотоодын хэргийг бүгд захиран шийтгэх яамны тэргүүн сайд, Бүгд ерөнхийлөн захирах сайдын яамны дэд сайдыг явуулахаар буй тул элчин сайд Ха, Ши Орос улсын нийслэлд эрхэм улсад хүн явуулна гэж хэлж эрхбиш бүтээн тэр элчин сайдаас хамгаалах бичиг авч ... ирүүлтүгэй, үүнийг маш сэмээр яаравчлан гүйцэтгэсүгэй. Бүгдийн яам ёсолмуй" гэжээ./8,т-479/

Ханддорж, Ширнэндамдин нарыг Петербургт байхад бусад олон улсын элчин сайдууд Монголын төлөөлөгчидтэй уулзан яриа шуугиан гаргах хүсэлгүй байсан юм. Учир нь юу гэвэл "Англи, Франц улсын элчин сайдуудтай учрах гэтэл тэд цөм өвчтэй учир чадахгүй, мөн Голланд улсын элчин сайд Монгол тусгаар улс болсныг албан ёсоор сонсоогүй тул учирч үл чадна, харин Японы элчин сайд Англи, Францын зэрэг орнуудын элчин сайдуудтай учирсан хойноо учирч болно" /1,Ф-А-2,Т-1,Хн-92,т-20/ гэжээ. Ийнхүү Монгол улсынхаа хамгийн чухал, тулгамдсан асуудлын нэг болох элчин сайдаа Хаант Орост суулгах, Англи, Франц зэрэг оронд хөл тавих өөрөөр хэлбэл тэдгээр орнуудаар тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх төлөвлөгөө нь нуран унасан юм. Гэсэн ч Монгол улс тусгаар тогтнолоо сэргээн Олноо Өргөгдсөн хаант улсаа тунхагласан тухайн үедээ дэлхийн аль ч улс гүрнээс хүсэн хүлээсэн хариу авч чадаагүй хэдий ч Монгол хэмээх түүхт ойлголтыг дэлхий нийтэд эргэн санагалзуулсан юм. /7,т,17/

Оросын засгийн газраас Монголын төлөөлөгчдийн итгэлийг хөсөрдүүлэхгүй, өөрсдөд нь итгэх итгэлийг хэвээр байлгах зорилгын үүднээс "Монголын тэргүүн сайд Эрдэнэ дайчин чин ван Ханддоржид Аннагийн тэргүүн зэргийн одон, дэд сайд Жонон бэйс Ширнэндамдинд Станиславын тэргүүн зэрэг хэмээх эрдэнэ одон, дэс түшмэл Цэрэндоржид, мөн эх зохиогч түшмэл Бавуудоржид Станиславын 2-р зэргийн одонг тус тус шагнаан" /14,т,474/ урамшуулжээ. Ийнхүү монголын төлөөлөгчид зорин

очсон хэргээ бүрэн гүйцэлдүүлж чадаагүй ч гар хоосонгүй 1913 оны 3-р сард Оросын нийслэл хотоос Их Хүрээнд хүрэлцэн ирсэн байна.

Төлөөлөгчдийн итгэл зүтгэлийг төрөөс үнэлж Монгол улсын хаан Богд Жибзундамба хутагтаас жинон ван Ширнэндамдинд "... Улсад туслагч гүнгийн зэрэг хүртээжээ." /5, т, 15/

Энэ л үеэс Ширнэндамдингийн байр суурь, нэр хүнд нь өсөж эхэлсэн нь илэрхий. Учир нь тухайн үед нь Монголын томоохон улс төрчид, дипломатч болох да лам Цэрэнчимэд, Ханддорж, Намнансүрэн нар байсан ба тэднээс суралцах зүйл Ширнэндамдин вантанд их байсан нь зүйн хэрэг билээ.

1911-1915 оны үе бол Жинон ван Ц.Ширнэндамдингийн хувьд улс төрийн талаар боловсрох, арга ухаанд суралцсан үе байлаа. 1914 оны дунд үеэр Богд хаанаас "...Тусгай зарлиг буулган хааны шадар сайдад" /5, т, 15/ тохоон талбисан нь Богд хааны итгэлт хүмүүний нэг болсон байна.

Хаант Орос улс их гүрнүүдээс Монголын талаар баримталж байсан байр суурийг ерөнхийдөө дэмжиж байсан боловч бий болсон байдлыг өөртөө хожоотойгоор ашиглан Монголд Оросын худалдаа, эдийн засгийн нөлөөг бэхжүүлэх, түүнийг баталгаатай болгох талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулсан болно.

Хаант Оросын засгийн газар санаачлан 1912-12-2-нд Монгол улстай найрамдал ба хавсран тогтоосон худалдааны гэрээ, 1913-10-23-нд Хятадтай Монголын асуудлаархи тунхаг бичигт тус тус гарын үсэг зуржээ. Эдгээр баримт бичгүүд нь нэг талаас Олноо Өргөгдсөн Монгол Улсыг "Автономит" болгон Хятадын харъяалалд оруулах, нөгөө талаас Монголд Оросын худалдаа, эдийн засгийн онцгой эрхийг тогтоох үндэс болсон юм.

1912 оны 10-р сард эхэлсэн Орос, Хятадын хэлэлцээр бүтэн жил үргэлжилжээ. Хаант Оросын засгийн газар нь Хүрээний эрх баригчдын сэтгэл санааг урьдчилан засах зорилгоор Монголын асуудлаар Орос, Хятадын хэлэлцээр хийгдэж буйг Монголын засгийн газарт албан ёсоор мэдэгдсэн байна.

Богдын засгийн газар Монголын асуудлаар Орос, Хятадын хэлэлцээр монголчуудын албан ёсны засгийн газрын араар явагдаж байгааг хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ албан ёсоор мэдэгджээ. Энэ тухай Богд хаант Монгол улсын Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яам хаант Орос, Хятадын засгийн газруудад адил утга бүхий эсэргүүцлийн ноот бичгүүдийг илгээсэн байна. Тухайлбал, Оросын консулын газар илгээсэн ноотод: "...Эрхэм улс, Дундад иргэн улс лугаа манай Монгол улсын хэргийг хэлэлцэн басхүү гэрээ байгуулах хэмээж буй хэмээн сонсогдох нь хэрэв үнэн болбол Монгол улсын хэргийг Монгол улсын засгийн хэрэг шийтгэх газар лугаа зөвлөхгүй, шууд хэлэлцэх нь ердийн цаазыг тэсрэхийн дээр хэрхэн тогтоох боловч манай улс хэрхэвч хүлээж чадахгүй" гэжээ. Мөнхүү ноотод цохон тэмдэглэхдээ, хэрэв гэрээ бичиг байгуулан найрамдсугай гэвэл эрхбиш манай засгийн газартай хамт нийлэн хэлэлцвэл зохино" /8, т, 489/ гэжээ.

Орос, Хятадын хэлэлцээр 1913 оны 10-р сарын 23-нд Бээжингийн тунхагт гарын үсэг зурснаар төгсгөл болжээ.

Таван зүйлээс бүрдсэн Орос, Хятадын хэлэлцээрийн 1, 2-р зүйлд Богд хаант Монгол улсын төрийн тусгаар тогтнолыг эвдэж, Дундад иргэн улсын хэмжээт эзэрхлийг тулган хүлээлгэх санаа шууд илэрхийлэгдсэн байна. Монголын талаар гаргасан тунхагийн зарим нууц санаа Бээжин дэх Оросын элчин сайд Хятадын Гадаад яамны сайд нар тунхагт гарын үсэг зурах үеэр солилцсон ноот бичигт мөн тусгагдсан байв. Энэхүү ноотын 1-р зүйлд: "Гадаад Монголын нутаг дэвсгэр бол Хятадын нутаг дэвсгэрийн нэгэн хэсэг мөн гэж Орос хүлээн зөвшөөрнө" /19,с,419/ гэжээ. Хятадын засгийн газар Монголтой холбоотой улс төр, газар нутгийн бүх асуудлыг Оростой тохиролцсоны үндсэн дээр шийдэж байхаас гадна Гадаад Монголын засаг захиргаа өөрийн орны талаархи аливаа асуудалд оролцох эрхтэйг уг ноотын 3-р зүйлд дурдсан байна.

Үүнийг монголын засгийн газар, улс төрийн томоохон зүтгэлтнүүд ихэд дургүйцэн хүлээж авсан билээ. Гэхдээ Монголын эс оршихуйн асуудлыг шийдвэрлэхэд гарсан томоохон саад нь Орос, Хятадын зөвшил төдийхнөөр хязгаарлагдсангүй. Учир нь Олноо Өргөгдсөн Монгол Улс нэгэнт бий болж, улмаар өөрийн бүрэн эрхт ёс, тусгаар тогтнолоо олон улсын талбар дээр зөвшөөрүүлэн хүлээлгэхийн төлөө явуулсан шургуу тэмцэл нь огт анхааралгүй үл тоомсорлон өнгөрч болох зүйл биш байснаар үл барам, айл хөрш хоёр их гүрэн ба бусад улсын гадаад бодлогод зохих хэмжээний нөлөө үзүүлж чадах /8,т,487/ байлаа.

Хаант Орос, Дундад Иргэн Улс хоёр Монголын тусгаар тогтнолыг цуцалж зөвхөн Ар Монголыг ДИУ-ын харъяаны автономит байлгахаар тохиролцож 1913 оны 11-р сард тунхаг бичиг гаргасанд нийт монголчууд дургүйцэн эсэргүүцэж байсан тул Жибзундамба хутагт шинэ жилийн шинийн нэгэнд Орос улсын дипломат төлөөлөгчийг хүлээн авахаас татгалзсан ажээ. /14,т-174/

Ийнхүү Хаант Орос, Хятад, Монгол 3 улсын эцсийн шийд хэлэлцээний ширээний ард л суух үлдсэн юм. Хүн төрөлхтний хар түүх болох дэлхийн ихэнх орныг хамарсан I дайн эхлээд удаагүй үе буюу 1914 оны 8-р сард Орос-Монголын хилийн заагт орших бяцхан гацаа Хиагтад 3 улсын төлөөлөгчид цугларсан юм.

Гурван этгээдийн хэлэлцээрт Оросын талаас тэргүүн нь Монгол дахь дипломатч төлөөлөгч бөгөөд Ерөнхий консул А.Миллер, Монголын талаас Дотоод явдлын яамны сайд да лам Дашжав /түүнийг хатуу байр суурьтай байсных нь төлөө Орос, Хятадын зүгээс буцаахад хүргэхэд оронд нь Ханддорж, Намнансүрэн, Ширнэндамдин нарын нэгийг ирүүлэхийг хүссэний дагуу Богдын засгийн газраас Ширнэндамдинг бүрэн эрхт сайдаар томилжээ. Хятадын талаас дэслэгч генерал Би Гуй Фан нар тус тус тэргүүлэн оролцов.

Ширнэндамдинд засгийн газраас ийм их итгэлийг үзүүлсэн нь дээр миний өгүүлсэн түүний нэр нөлөө нилээд их болж байсан илрэлийн баталгаа юм.

Ширнэндамдингийн тухай Оросын элчин төлөөлөгч Миллерээс засгийн газартаа цахилгаан утсаар мэдээлэхдээ: Ширнэндамдин нь хэдийгээр өндөр хэргэм зэрэггүй боловч Богд гэгээнтэй ойр байдгийн

хувьд Хүрээний ноёдын дунд онцгой байр эзэлдэг. Тэрээр ухаантай, эелдэг, биеэ зөв авч явдаг тул улс төрийн хувьд боловсроогүй, бүдүүлэгдүү монгол ноёдын дунд онцгойрон ялгардаг. Ширнэндамдин Хятадын бүрэн эрх барих төлөөлөгч Би Гуй Фантай урд нь Бээжинд танилцсан" /20,т,554/ хэмээн илтгэжээ.

Ширнэндамдин нь 1914 оны 11-р сарын 7-ноос, 15-р хурлаас эхлэн 3 этгээдийн хэлэлцээрт оролцож эхэлжээ. Монголын төлөөлөгчид ялангуяа Ширнэндамдин автономит эрхийг аль болохоор хязгаарлаж, цахилгаан утас, төмөр зам, шуудан холбоо зэргийг өөрийн хяналтанд байлгах гэсэн Хятадын төлөөлөгчдийн үйл ажиллагааг эсэргүүцэн Хиагтын хэлэлцээг таслах нь зүйтэй гэж үзэх болсон байна. Тухайлбал, "Богд эзэн хаан, Улсын Эх дагина нарт харштай гариг Лхагва, Бямбыг цээрлэж", зарим тохиолдолд өвчнөөр шалтгаан хойшлуулж байсан нь нэн сонин. Энэ талаар ноён Миллер Гадаад явдлын яамны сайддаа "... Монголын төлөөлөгчдийн ийм байр суурь нь юуны өмнө тэд засгийн газраас тавьж байгаа гол шаардлагуудыг биелүүлэн Хятадаас буулт хийлгэж чадахгүй байгаа хариуцлагаас зайлсхийхийн тулд Хятадын уян хатан бус байр сууриас шалтаглан хэлэлцээг таслаад өөрсдөө цэвэр үлдэх гэсэнтэй нэлээд холбоотой" /11,т-24/ гэж тайлбарлажээ. Ийнхүү Монгол улсын хувь заяаны тулгамдсан асуудал дээр зүтгэл гарган бүтэн 7 сар хуралдан Монгол улсыг автономит хэдий ч өөртөө эзэрхэх улсын статустайгаар оршин тогтнох болжээ. Гадаад Монголын автономийн тухай гурван улсын хэлэлцээрт 1915 оны 5-р сарын 25-нд гарын үсэг зурснаар Хиагтад болсон гурван улсын бага хурал ажиллагаагаа дуусгасан байна.

Энэхүү хэлэлцээрээр тусгаар тогтносон Богд хаант Монгол улсын бүрэн эрхт байдал хэдийгээр ноцтой зөрчигдсөн ч тэр нь эрх хэмжээний асуудал болохоос бус Богд хаант Монгол улсын оршин тогтнож байгааг үгүйсгэх зүйл биш байв. Энэ талаар судлаач Ж.Бор "Монголын улс төрийн гадаад бодлого, дипломатын уламжлалын зарим асуудал" хэмээх бүтээлдээ: "Гурван улсын Хиагтын гэрээгээр Богд хаант Монгол улсын олон улсын эрх зүйн эрхийн хүрээ хязгаарлагдсан авч тэр нь эрх хэмжээний асуудал болохоос бус тусгаар тогтнолоо алдсан хэрэг харахан биш байлаа. Учир нь өөрийн тусгаар засгийн газар, засаг захиргаа, төрийн тэргүүн, албан яамд, хууль цааз цэргийн байгууллагуудтай байсан зэрэг нь олон улсын эрх зүйн эрх эдлэгч этгээд мөн болохыг нотолж байна" /21,т,175/ хэмээн дурджээ.

Гурван этгээдийн хэлэлцээрт оролцогч талууд гэрээг орос, хятад, монгол, франц хэл бичгээр үйлдсэний гадна маргаан гарах аваас франц эхийг үндэс болгон баримтлахаар болжээ.

Ийнхүү Богд хаант Монгол улс нь их гүрнүүдийн даралт шахалтад автан тусгаар тогтнолоосоо татгалзаж улс төрийн хувьд Хятадын харъяанд, худалдаа, эдийн засгийн хувьд Хаант Оросын эрхшээлд тус тус орсон юм. Гэсэн хэдий ч Ширнэндамдин нарын зэрэг туршлагатай, гарамгай дипломатчдын сэтгэл зүтгэлийн ачаар монголчууд дотоод асуудлаа бүрэн мэдэх өргөн автономит эрхийг хадгалж хоцорсон нь Монгол орон бүрэн тусгаар тогтноход чиглэсэн нэгэн алхам байв.

Хиагтын бага хурал дуусмагц Юань Шикайн засгийн газар яаравчлан 3 улсын гэрээний 7-р зүйлийг зууран барьж, 1915 оны 6-р сард мөнөөх Чэнь-Луг ДИУ-аас Хүрээнээ сууж ерөнхийлөн хэрэг шийтгэх сайдаар томилон явуулжээ. Чэнь-Лу Хүрээнд хүрэлцэн ирж 1915 оны 10-р сарын 4-ний өдөр тушаалаа хүлээж аваад, юуны урьд Ар Монголын эрх баригч олон ван гүн нартай уулзаж ярилцахад тэдний зарим тухайлбал дэд сайд Ширнэндамдин: Танайхаас Жибзундамба Хутагт Богд хаан өргөмжилснийг нэгэнт сонсоод хариу талархлыг цахилгаанаар мэдэгдсэн тул өргөмжлөлийн хэрэг нэгэнт дууссан гэж хэлж байжээ. /22,т,94/ Энэ нь Богд хаант Монгол улсад хүчээр тулган хүлээлгэсэн хэмжээт эзэрхлэлийг монголчууд тэр дундаа Ширнэндамдин ван хэрхэн хүлээн авч үзэж байсныг зарим талаар харуулж байгаа явдал юм.

Хятадын засгийн газар энэ мэтээр Хүрээний эрх баригчдын зүгээс дуугүй эсэргүүцэлтэй тулгарч, хэмжээгүй эзэрхлэл байтугай хэмжээт эзэрхлэлийн эрхээ ч эдэлж чадахгүйд хүрч байв. Иймд Юань Шикай, Хүрээний эрх баригчдыг хүчлэн шаардахын хажуугаар хөхүүлэн шагнах зальхай арга ч хэрэглэж байжээ. 1915 оны 12-р сард Дундад Улсын ерөнхийлөгчөөс I зэргийн одонгоор Сайн ноён хан Намнансүрэн, Жинон ван Ширнэндамдин нарын хүмүүсийг шагнажээ. Гэвч Юань Шикайн энэ зусар арга бас амжилтанд хүрээгүй юм. Хүрээний эрх баригчид Хятадын бэлэг сэлт, одон мэтийг хүлээн авч байсан боловч тэд Монгол улсын бүрэн эрхт байдлыг аль болохоор хамгаалахыг оролдож байсан юм. Ширнэндамдин нарыг Нийслэл Хүрээнд ирэхэд Бүгд ерөнхийлөн захирах яамнаас 3 улсын гэрээ хэлэлцээр тогтоосон учир айлтгаад үе улирах төрийн бэйлийн хэргэм шагнаан олгожээ./3/ Мөн Монгол улсын хаан Богд Жибзундамбаас Ширнэндамдинд "...вангийн хэргэм шагнаж, гурван нүдний тогосын отго, улбар шар жолоо шагнаан" /5,т,15/ хүртээж, Шүүх яамны дэд сайдын тушаалаас чөлөөлж өөрийн дэргэдэх шадар сайдаар томилжээ. Ширнэндамдин мөн онд Сайн ноён хан Намнансүрэнгийн оронд ерөнхий сайдын тушаалыг нэг сар гаруй хашжээ.

Ийн байтал 1915 оны 2-р сард ГЯЯ-ны сайд чин ван Ханддорж Богдын ордны дайллагын үеэр учир битүүлгээр үхэв. 1917 онд Сайн ноён хан Намнансүрэн "биеэ худалдахаас татгалзсан" учир бас л битүүлгээр өөд болжээ. Монголын үндэстний нэгдсэн тусгаар төр улс байгуулах үзэл санааг идэвхтэй дэмжигч Богд хааны ойр дотнын шадруудаас гүн Цэрэндорж, шадар сайд ван Ширнэндамдин, жалханз хутагт Дамдинбазар, Цэцэн хан Навааннэрэн нар нилээд нөлөө бүхий хэсгийнхэн болоод байлаа.

1919 оны 10-р сард Хятадад Японы талыг барьсан Аньфу нам ялж, хэрэг эрхлэх сайдаар Сюй Шү-Жан ирэв. Тэр "Монголын хойчийг сайжруулах 8 зүйл" гэдгийг гаргаж, шанзав Бадамдорж, гүн Цэрэндорж нараар гарын үсэг зуруулжээ. Удалгүй 1919 оны 11-р сарын 17-нд Хятадад сайн дураар орох өргөх бичгийг үйлдэн Монголын хар, шар ноёд нийлсэн 16 хүний гарын үсэг зурагдсанаар 1919 оны 11-р сарын 22-нд Хятадын ерөнхийлөгч Ар Монголын өөртөө засан тогтнох эрхийг устгаснаа зарласан байна.

Энэ 16 хүний тоонд Ширнэндамдин вантны нэр ороогүй нь тэрээр тусгаар тогтносон улсын төлөө цаашдаа ч тэмцэх болно гэдгээ харуулсан нь илт юм.

Ийм үед Хятадын ерөнхийлөгчид бараалхаж 9 цагааны бэлэг хүргэх "Жалханз хутагт, Дилав хутагт, Засагт ханы ахай бэйл, Сэцэн хан Навааннэрэн, чин ван лам Мөрдэндэв, дархан чин ван Пунцагцэрэн, Баргын чин ван Пунцагравдан, итгэмжит бэйс Цогт-Очир, Урианхайн да лам, дөрвөдийн бэйл Сангабазар, бэйс Аюурзана, ван Ширнэндамдин"/2/ нар Хатанбаатар ван Магсаржав, Манлайбаатар нартайгаа нууц хэлэлцэн энэ хоёрыгоо үлдээгээд, тэд уг хэлэлцээн дээрээ "Монголын хуучин эрхийг олох арга сүвэгчлэн явахаар хүмүүст захисан, тэднийг ирэх цагт өмнө зүгийн байдал ямар болох зэргийн нарийн мэдээ хурааж жич зөвлөлдөж тогтохоор" үлджээ.

Ширнэндамдин нар Цао Кун тэргүүтэй шинэ засгийн газарт өргөдлөө гардуулан өгөөд, үүний далимд генерал Сюй Шү-Жан Хүрэнээс буцсан учир хүрээнд хуучин сууж байсан Хятадын түшмэл Чен И-г монголд буцааж очуулахыг хүсэж байгаагаа илэрхийлжээ. Монголын төлөөлөгчдийн тэр хүсэлт нь Хятадын төв засгийн газрын эрх Хятадын цэргийн эрхтний нэг бүлэглэлийнхээс нөгөөд шилжсэнтэй уялдан нийцсэн хэрэг байсан юм. Төлөөлөгчдийг 9 цагааны бэлэг хүргэж ирсэн тухайд хүн бүрд хэд хэдэн мянган янчаан шагнаснаас Ширнэндамдинг 3000 янчаанаар шагнасан байна. Гэвч тэдний далд санаа биелэгдэх янзгүй болсон бөгөөд байдал нэгэнт ойлгомжтой болсон тэр үед төлөөлөгчид итгэл алдран намрын эхэн сарын 11-нд Бээжингээс гарчээ.

Энэ үед хувьсгалын хэргээр Орос улсаас тусламж гуйхаар Данзан, Лосол, Чагдаржав нарын 7 хүн хойш одож Хүрээнд буй Хатанбаатар, Дамдинсүрэн, жинон ван Цогбадрах, ван Ширнэндамдин нар энд тэнд хуралдаж Хятадын дарлалаас яахин ангижрахыг хэлэлцэх боловч оновчтой аргыг олохгүй дэмий л урьд устгасан 3 этгээдийн гэрээг Хятадаас хүчээр эвтгэснийг буруутгах боловч, эгээрлийн бичиг зохиож Оросын консулд өгөх, мөн Бээжинд суугаа Америк, Англи, Японы элчинд нэгэн адил тусламж гуйхыг эрмэлзсэн нь нэгэнт бүтэшгүй болжээ.

Эрдэнэ Жинон ван Ширнэндамдин 1921 онд ялсан Ардын хувьсгалын ялалт, өрнөлт, бататгалд өөрийн гэсэн хувь нэмрээ оруулах үйлст зүтгэн чармайсан хүний нэг юм. Уг хувьсгалын урьдач нөхцөл, бэлтгэлд түүний хичээл зүтгэл ямархан байсан гэдгийг дээр нэгэнт дурдсан билээ.

Хувьсгалт нууц бүлгэмийнхэн үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцлийг төр засгийг халж өөрчлөх зорилготой холбож тавих болсноороо үндэсний эрх чөлөөний тэмцэлд шинэ агуулга оруулсан юм. /9, т.128/ Нууц бүлгэмийнхэн үндэсний үзэл бүхий лам, ноёдтой түүн дотроо Жинон ван Ширнэндамдин болон дилав хутагт Жамсранжав, да лам Пунцагдорж, гүн Гомбо-Идшин зэрэг Монголын тусгаар тогтнолын төлөө санаа тавьдаг тэдэнтэй холбоотой ажиллахыг эрмэлзэж байсан юм.

1921 оны Ардын хувьсгал ялж шинэ төрийн тогтолцоог цогцлон байгуулахад Ширнэндамдин ямар нэгэн суудалд залраагүй нь түүний

хашир ухаан, цагийг хүлээзнэх аястай холбогдовч энэ үйл явдал нь анхнаасаа тэргүүлэгч бүлгийг хавчих оролдлого байсантай холбоотой.

1921 оны хувьсгалын гол зорилтын нэг болох "Монгол улсын тусгаар тогтнолыг" хөрш орнууд болон дэлхий дахинд хүлээн зөвшөөрүүлэх явдал байв. Үүний үр дүнд Ардын засгийн газраас 1921 оны 9-р сард Монгол Ардын засгийн газрын хуралдаанаар Орос улстай найрамдалт харилцаа тогтоон хууль зүйн дагуу гэрээ бичгээр баталгаажуулах асуудлыг хэлэлцэн Ерөнхий сайдын орлогч бөгөөд сангийн яамны сайд Монгол ардын намын Төв Хорооны тэргүүлэгч Солийн Данзан тэргүүтэй Монгол ардын засгийн газрын албан ёсны төлөөлөгчдийг томилон Зөвлөлт Орос Улс руу мордуулахаар шийдвэрлэжээ. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг тал талаас нь нягтлан ярилцсаны эцэст "Монголын бүх цэргийн жанжин, Цэргийн яамны сайд Дамдины Сүхбаатар, Гадаад хэргийн яамны дэд сайд Балингийн Цэрэндорж нарыг явуулахаар тогтсоны дээр Богд хаантай тохиролцсоны дагуу түүний бие төлөөлөгчөөр Эрдэнэ Жинон ван Ширнэндамдинг /14, т.169/ төлөөлөгчийн албан бус гишүүнээр явуулахаар шийдвэрлэсэн байна. Ийнхүү Ширнэндамдин Монгол улсын хувь заяанд онцгой ач холбогдолтой хэлэлцээрт дахин оролцох болсон байна.

Энэ удаагийн хэлэлцээрт Ширнэндамдинг томилсон нь Монгол улсын гадаад харилцааг сайн мэддэг, гадаад бодлогын түүх уламжлалыг сайтар судалсан, өөрийн гэсэн туршлагатайг харгалзан томилсон нь санамсаргүй зүйл бус гэдэг нь ойлгомжтой. Төлөөлөгчдийн зуучлагчаар Сибирийн нилээд шаггүй хувьсгалч гэгдэх Б.Шумяцкий нар бага хурлын ажлын тухай тодорхойлолт, лавлагаа гаргаж өгч байв. Тэрээр Ширнэндамдинг "Энэ бол Монголын төлөөлөгчдийн албан ёсны бус гишүүн, Хутагтын бие төлөөлөгч, феодал лам нарын намын ухаалаг дипломат нарын нэг. Урьд олон янзын гэрээг боловсруулахад оролцож байсан. Түүнийг Хятадын талыг баримтлагч хүн гэж үздэг. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд түүний гүйцэтгэх үүрэг нь Зөвлөлт Оросын тухай хутагтын "мэлмий" болж ажиглалт хийх, мэдээж хэрэг өөрийн төлөөлөгчдийн гишүүдийг ч хараанаасаа үл гаргах явдал юм /15, т.45/ гэж илтгэжээ.

Монголын төлөөлөгчид "Тагна, Тува, Дотоод Монголын зэрэг овогтныг нэгтгэх тухай уул гэрээнд оруулах саналыг гаргаж байсан боловч уг санал нь бусдыг эзэрхэх гэсэн бодлого хэмээн хэрэгсээгүй"/2/ байна. Хэлэлцээрийн хамгийн чухал хэсэг нь Гадаад Монголын тусгаар тогтнол ба түүнийг Зөвлөлт Орос улс хүлээн зөвшөөрөх асуудал байв. Энэ асуудлаар хоёр тал нилээн хэлэлцсэний эцэст харилцан буулт хийж "Оросын зуучлалаар БНХУ ба чөлөөт Монголын хооронд ойрын үед хэлэлцээр болох" тухай заалтын чөлөөт Монгол хэмээх үгсийг Данзан нар Монголын тусгаар тогтнолыг Зөвлөлтийн тал дэмжиж байна хэмээн ойлгожээ. Хэлэлцээрт 1921 оны 11-р сарын 5 буюу олноо өргөгдсөний 11 он, 10 сарын шинийн 6-нд Оросын талаас Духовский, Гец нар, Монголын талаас Данзан, Сүхбаатар, Ширнэндамдин нар гарын үсэг зурж тамга даржээ.

Хөгжлийн үндэсний ардчилсан үзэл баримтлалын чухал бүрэлдэхүүн хэсэг нь эдийн засгийн бодлого байдаг. Энэ талаар Монголын нам төрөөс явуулсан бүтээлч эрлийн нэг чухал үр дүн бол "Эдийн засгийн үндсэн бодлого" хэмээх баримт бичиг юм. Уг баримт бичигт улс орны эдийн засаг үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх чухал хүчин зүйл бол хүн амыг олон болгох явдал гэж үзээд буриад, торгууд, дотоод монгол, баргын зэрэг монгол үндэстнийг Монгол улсын хязгаар дотор дуртай аваас оруулан авч газар нутаг гарган олгож үүрдийн харъяат болгон Монгол улсын соёлд багтаах хүн амыг элдэв халдварт өвчин эмгэгээс ангижруулж эрүүлжүүлэх, эрдэм боловсролд сургахыг чухалчилна /16, т. 136/ хэмээн заасан байна. Энэ нь аливаа үндэстэн нэгдмэл байх нь уг үндэстний хэл, соёл, урлаг зүй зохистой хөгжих үндэс болдгийг эх үүсвэр болгон соёл иргэншил хүн ам зүйн үүднээс үндэсний асуудалд хандсан чухал шийдвэр байсан юм.

Энэ л үүднээс 1923 онд ерөнхий сайд Данзан, хичээнгүй сайд Цэрэндорж, Элбэгдорж гурваас тус Монгол улсын тусгай эрх мэдэлтэй болсон учир дотоод Монголын зэрэг монгол үндэстнээ таниулж нааш Гадаад Монгол лугаа нэгтгэхийг оролдох зорилтын үүднээс Ширнэндамдинг Хятадад томилон илгээжээ.

Ширнэндамдин даалгаврыг аван Бээжинд очоод Өвөр Монгол, Баргын нөлөө бүхий хүмүүс болох Ордосын Бандид гэгээн, Найман ван, харчины ван Гүнсэнноров, мөн Алтан, Цэрэндонров, баргын Мэрсэ Фуминтай уулзаж, Ар Монголд шинэ тогтсон дэглэм, тусгаар тогтносон явдал монголчуудын нэгдэн нийлэх хэзээний хүсэл мөрөөдөлд сайхан боломж нээгдлээ хэмээн ухуулж улс орныхоо дотоод байдлыг танилцуулжээ.

Ширнэндамдингийн хэлж ярьсныг дээрх хүмүүс харилцан адилгүй хүлээж авч байсан юм. Жишээ нь, Найман ван : - Гадаад Монголын эрхийг ноёд, хутагт нар нь мэддэггүй, ард нь мэддэг байхад, та ноёд эсэргүүцэх нь яасан юм бэ? гэж байжээ. Үүнд, Ширнэндамдин :- Бүх монгол үндэстнийг нэгтгэн голомт босч байхад, дотроо эвдэрвээс гадаадад залгигдахад дөхөм болно. Иймд болохгүй хэмээн хариулж байжээ. /2/ Харчин ван Гүнсэнноров, Ширнэндамдингийн хэлсэнд талтай хандаж байсан байна. Үүний зэрэгцээ Мэрсэ, Алтан нар Ар Монголтой холбоо тогтоож байжээ. Тэрээр Хятадад 7 сар шахам болоод 1924 оны хавар эргэн ирж ярьж хэлэлцсэн байдал учраа Данзан, Элбэгдорж, Цэрэндорж нарт танилцуулсан байна.

Хятад улс 1923-1924 онд Хятад-Оросын гадаад харилцааг сэргээхийн тулд ЗОУ-тай хэлэлцээ хийсэн байна. Учир нь Хятад улс Оросуудын Ар Монголд явуулж байгаа ажиллагаанд нэн их зэвүүцэж байв. Энэ үед "Ар Монголын их хаан Богд гэгээн нас барсан байв. Ар Монголын төрийн эрхийг Чойбалсан хүлээж аваад Бүгд Найрамдах Улсыг байгуулахаар шийдвэрлэж" буй нь илэрхий болсон үе байв.

Монгол орон ЗХУ-ын туслалцаатайгаар тусгаар тогтнолоо сэргээн тогтоож, улмаар ардын засгийг бэхжүүлэх талаар анхны алхмуудаа хийж байсан тэр үед ЗХУ, Хятад улс ~~хоёрын~~ ~~хоёрондын~~ асуудлуудыг зохицуулах ерөнхий зарчмуудын тухай 1924 оны 5-р сарын 31-нд гэрээ

байгуулж түүнийхээ тавдугаар зүйлд: Гадаад Монгол бол Дундад иргэн улсын нэгэн хэсэг газар гэдгийг ЗХУ хүлээн зөвшөөрч тэндэх Хятадын бүрэн эрхт байдлыг хүндэтгэнэ хэмээн заасан байна.

Харин 1924 оны 6-р сарын 25-ны "Ардын эрх" сонинд "Орос, Хятад хоёр улсын гэрээ тогтоосон тухай" өгүүлэл хэвлэгдэн гарч: "Монголын ард түмэн дундад улсын харгис засгийн дахин дарлан бурангуйлахыг тэсвэрлэхгүй... хэзээд эсэргүүцэн тэмцэх болно" гэсэн утгатай зүйлс бичигдсэн байна. /17, т.19/

Дээрх гэрээг байгуулсан явдал нь Ширнэндамдинг дахин Хятадад илгээхэд хүргэсэн байна. Энэ удаагийн явалтаараа "Банчин богд Баруун зуугаас гарсан нь хойшоо ямар хэргээр явах, Монголд ирэх санаа буй үгүйг мэдэх, мөн Оросоос Бээжин хотноо элчин сайд суулгаж буй Хятад, Орос хоёр Монголын тухай ямар гэрээ хэлэлцээ хийх зэргийг" мэдэх даалгавар аван оджээ. Тэрээр энэхүү даалгаврыг авч явахдаа Судар бичгийн хүрээлэнгээс ном цуглуулах нэрийдлээр явсан байна.

Удалгүй Бээжин ороод Дотоод Монголын Мэрсээ, Фуйминтай, Алтан, Ордосын Бандид гэгээн, Наянт ван, Харчин ван Гүнсэnnоров нартай уулзаж ярилцсан байна. Тэд Ширнэндамдингаас асуусан нь: - Монголын байдал ямар байна? хэмээн асуухад нь: -Хуучин засаг ван гүнгүүдээс чадвартай нь хэвээр эрхээ барьж буй, сонгуултны засагтай болсон хэмээн хариулсан байна. Тэрээр хамгийн чухал даалгавар болох Монголын талаархи Орос, Хятадын хэлэлцээрийн дүнд Бээжин хотноо сууж буй Оросын элчин сайд Карахантай уулзаж: - Эрхэм улсын тусламжаар манай Гадаад Монгол сайн болж, иймд бүх монгол үндэстнийг нэгтгэхийг хүсдэг ба монгол үндэстэн нааш цааш харилцах өөрсдийн санал онолоо мэдэлцэж байх тухай тусламж үзүүлэхийг хүснэ гэхэд элчин сайд Караханаас: - болно /2/ хэмээн хариулсан байна.

Эндээс нэгэн зүйл ажиглахад Ширнэндамдин нь угаас монгол үндэстнээ нэгтгэх үзэл санаатай байсан нь өмнөх төрүүдийн үед ч тэр ялангуяа шинэ залуу засгийн бодлогыг бусад монгол үндэстэндээ таниулахын зэрэгцээгээр мөн нэгдэн нийлэхийг уриалж байсан нь баримтаас харагддаг юм.

Ширнэндамдинг Бээжинд байхад Ерөнхий сайдын жинхэнэ орлогч Амар, НТХ-ны нарийн бичиг Гэлэгсэнгэ, Дотоод яамны сайд, Сэцэн хан Навааннээрэн нар тэнд очсон байна. Тэд Ширнэндамдингийн ажил байдалтай танилцаж, ер нь тэдгээр хүмүүс Хятадын хувьсгалт хүчин түүний дотор Өвөр Монголтой хэлхээ холбоо тогтоох зорилготой байсан бололтой. Ширнэндэмдин 1924 оны зун эргэж ирээд Ерөнхий сайд Цэрэндоржид тайлагнаж, олж мэдсэн, цуглуулсан материалаа өгчээ.

✓1924 оны 11-р сарын 8-нд Улсын анхдугаар их хурал нээгджээ. Улсын анхдугаар их хурал, тус улсын улс төр-эдийн засгийн зорилтын тухай шийдвэр гаргаж Ардын Бүгд Найрамдах улсын үндсэн хуулийг баталжээ. Үндсэн хуульд зааснаар нийт иргэдээ жинхэнэ ард, феодал хэмээн хоёр хувааж нэг хэсгийнх нь улс төрийн эрхийг нь хассан ба нэг хэсгийг нь нам төр, улс төр олон нийтийн байгууллагын итгэлтэй хэсэг гэж итгэл найдвар үзүүлэн хамгийн түрүүнд нам, эвлэлийн гишүүнд элсүүлэн удирдах

тушаалд дэвшүүлж байлаа. Энэхүү шийдвэрийн гадна Ширнэндамдин үлдээгүй нь ойлгомжтой юм.

1924-1927 оны үед явуулсан арга хэмжээний дүнд улс орны нийгэм-эдийн засгийн байдалд ахиц дэвшил ихээр гарч байсан юм.

Энэ үед өмнөд хөрш Хятадад Чан Кайши тэргүүтэй баруун гоминьданчууд 1927 оны 4-р сарын 12-нд Шанхай, Нанжинд хувьсгалын эсэргүү эргэлт хийж, улмаар мөн сарын 18-ны өдөр Нанжин хотод "Үндэсний засгийн газар" гэгчийг байгуулсан. Ийнхүү хятадын 1924-1927 оны хувьсгалыг дараад, уг хувьсгалыг дэмжиж байсан ЗХУ, БНМАУ-ыг шууд эсэргүүцэж дайсагнах болсон юм. /13, т.154/

1927 онд НТХ-ны дарга Ц.Дамбадорж Ширнэндамдинг хөвгүүн Содномвандааар ирж уулз хэмээн дуудуулсны дагуу ирж уулзвас дахин Бээжин хотод очиж, Жан Золинтой уулзах, Монголын талаар ямар бодолтой буй зэргээр илгээхэд шууд зөвшөөрөн одсон байна. Энэ удаа мөн л ДИУ-аас /Судар бичгийн хүрээлэнгээс/ судар ном цуглуулах учиртай хэмээн явжээ. Энэ тухайд: "Эдүгээ манай судар бичгийн хүрээлэнгээс ДИУ-ын харъяат Бээжин, Мүгдэн, Хөх хотын зэрэг газраа Монгол үсгийн Ганжуур, Данжуур ба Монгол улсын их түүхэнд холбогдох судар ном зүйлийг эрэн олж ирүүлэхээр Ширнэндамдинг хэлмэрч харц Сономыг дагалдуулан 6 сарын хугацаагаар алив дотоод, гадаад газар орны эрх баригчид ба цэрэг, цагдаа, түшмэл, ард нар учрыг мэдэж одох, буцаахад саад үгүй шулуун шударга, өнгөрүүлэх ажаамуу"/1, Ф-13, Хн-138, т-40,/ хэмээн илгээсэн байна.

Тэд 1927 оны зун Бээжин хотноо очсон байна. Тэрээр Наянт ван, харчин ван Гүнсэnnоров, гүн Дэчинравдан, оргодол ван Доржпалам, баргын ван Пунцагравдан, Банчин Богдын сойвон төвд нарын нилээд олон хүмүүстэй уулзсан байна. Наянт ван, харчин ван Гүнсэnnоров, Доржпалам нараас: -Монголын байдал ямар байна? хэмээн асуухад нь Ширнэндамдин: -Хуучин ноёд түшмэд үгүй болж сонгууль ба ардын засагтай болсон хэмээн хариулжээ. Мөн харчин ван Гүнсэnnорвоор хэлмэрчлүүлэн Жан Золинтэй уулзсан байна. Жан Зо-Лин Ширнэндамдингаас: -Гадаад Монголын ноёд, түшмэд эрхгүй болсон гэж үнэн үү. Одоо Монголын хэргийг хэн мэдэж буй гэх зэргээр асуухад Ширнэндамдин: -Ван, гүн, ноёдууд эрх мэдэлгүй болсон нь үнэн. Сонгуулийн дарга тавих болсон. Монголын хэргийг хурлаар мэдэж буй. Танайд мал гаргахгүй буй нь дотоодын аж ахуй нэлээд үрэгдэж ховордсонтой холбоотой хэмээн ярилцжээ. /2/ Энэ удаа Бээжинд 2 сар гаруй болжээ.

1929-1932 онд Монгол даяар "Зүүний нугалаа" хэмээх коммунист хийрхэл болсон юм.

1928 онд МАХН-ын ҮII их хурал болж түүгээр Үндэсний ардчилсан хувьсгалын зөв чиг баримтлалыг таягдан хаяж сталинизм, коминтерний шууд шахалт түлхээсээр Монголд социализм байгуулах балмад санаархлыг улс төрийн бодлого болгож "капиталист биш хөгжлийн зам" хэмээн тунхаглажээ. Уг их хурлаас гаргасан шийдвэрүүд нь үндэсний ардчилсан хувьсгалын чиг шугамаас гажиж "капиталист биш хөгжлийн

зам" нэрийн дор социализм байгуулах гаднын тулгалтыг үг дуугүй хүлээн авч хэрэгжүүлэх практик алхамд оржээ. Тухайлбал "Хуучны үлдэгдэл ван гүн нар ба ихээхэн хутагт хувилгаадын эдийн хувиар эзэрхэх"-ийг халахаар заасан юм. Энэ нь олон зуун феодал агсад, хутагт хувилгаад сүм хийд, чинээлэг аж ахуйтны хөрөнгийг хүчээр хураан авч өмч эзэнгүйдэн хоосорч хуримтлалын эх үүсвэрийг боогдуулан хүнийг, эдийн засгийг егүүтгэн хэлмэгдүүлж Монголын нийгмийн хөгжилд асар их хор учруулахад хүргэжээ. /18,т-24/

Энэхүү ёс бус үйл ажиллагааг үндэсний ардчилсан хувьсгалын чигийг тууштай баригчид хүлээж авахаас татгалзан эсэргүүцсэн юм. Хөрөнгө хураалтын асуудлаар МАХН, Коминтерний хооронд, МАХН-ын удирдлага, намын дотоодод зөрчил хагарал гүнзгийрсэн байна. Иймээс төрийн удирдлагад хүч түрэн гарч ирсэн зүүний удирдлага юуны түрүүн баруунтнуудыг шахах хөдөлгөөн өрнүүлээ. Баруунтны толгойлогч гэгдэх Дамбадорж, Жадамба Жамсрано нарыг намаас хөөжээ. Ардын төр олон жил гадаад эгзэгтэй, ээдрээтэй бүхэндээ томилон байсан Ширнэндамдинг ам цуурсан хэргээр цаазлав. Ам цуурсны учир нь хөрөнгө хураах буруу хэмээснээс л болжээ. Феодалын хөрөнгийг хураах тэр хураагдсан хөрөнгө дээр үндэслэн хамтрал коммун байгуулсан нь феодалын эдийн засгийн нөлөөг бууруулсан авч, ард олонд нялзсан юмаар бага, үндэсний баялгийг үрэн таран хийж, аж ахуйд хохирол учруулснаараа үр дүн ашиг туснаасаа илүү хор уршиг нь их байв. Нөгөөтэйгүүр хөрөнгө хураагдсан феодалын аж ахуйг ч цаашид улам хавчин тэдний хэвийн амьдралыг алдагдуулж хүний эрхийг бүдүүлгээр зөрчсөн явдал орон нутагт ихээхэн гарч байв. Энэ үед Ширнэндамдингийн мал хөрөнгийг мөн хураажээ. 1931 онд Ширнэндамдингаас 30 төгрөг, хүүгээс нь 70-аад төгрөг авах ёстой байсан боловч сумын төвөөс тайж хэмээн хэд дахин өсгөж Ширнэндамдингаас 153 төгрөг, хүүгээс нь 350 төгрөг авна хэмээн сумын захиргаанаас шийдвэрлэжээ. Үүнд бухимдсан "...Ширнэндамдин хэрэв ийнхүү олон дахин өсгөн татварлах юм бол миний бие ба хөвгүүн тэсвэрлэх аргагүй болж удахгүй өлсгөлөнгийн байдалд хүрнэ" хэмээн албан татвараа хөнгөтгөхийг хүсчээ. Бас хурааж авсан хөрөнгөн дээр нь байгуулсан хамтрал нь үр ашиг бага байгаа юм /2/ гэжээ. Эд бүгдийг нь мушгин гуйвуулж өлсгөлөн тохиолдох нь, хамтрал ашиггүй гэж ардын засгийн бодлогын эсрэг цуурхал дэгдээсэн хэмээн Дотоодыг хамгаалах газраас Ширнэндамдинг 1931 оны 10-р сарын 31-нд хөдөөнөөс баривчилжээ. Ширнэндамдин мөрдөн байцаалтын явцад өөрийн бүхий л хийж оролцож байсан ажил, хөрөнгө хогшил, бодож санаж байсан зүйлээ үнэн зөв мэдүүлсэн байна. Гэтэл үнэн шударга мэдүүлгийг нь өөрийнх нь эсрэг гуйвуулан ашиглаж, хуучин том феодал, Богд хааны үеийн сайд, Автономитыг анх байгуулах ба устгахаар толгойлон оролцсон, Хаант Орос, Хятадаас одон медалиар хүртэл шагнагдсан, үндэсний үзэлтэн, Нармай Монголыг байгуулах гэсэн, Банчин богд, Өвөр Монголын ноёдтой дотно харилцаатай байсан, 1924 онд Бээжин дэх Зөвлөлтийн элчинд зүй бус үг хэлсэн, Зөвлөлт, Хятадын хооронд Монголын талаар байгуулсан хэлэлцээрт Монголыг Хятадын хэсэг хэмээсэн гэж хэлж

байсан. Монголыг Хятадад нэгтгэхийг эрмэлзсэн, эд бүгдийгээ Цэрэндорж, Цэвээн Жамсрано, Дамбадорж нарт хэлж байсан гэдэг зэмлэлийг тулгаснаас гадна тэр үед олны дунд дэлгэрсэн Орост юм ховор, үнэтэй, Банчин Богд Баргад байгаа, Монголд ирэх гэнэ, баячуудын хөрөнгийг хураах гэнэ" гэх мэтийн эзэнтэй эзэнгүй дэл сул яриаг түүнийг сэдэж гаргасан болгон 1931 оны 11- сарын 6-ны тусгай комисст шилжүүлэн 10 хоногийн дараа буюу 11-р сарын 16-нд Дотоод явдлын яамны онцгой комиссын тогтоолоор буудан алж бүх хөрөнгийг нь хураажээ.

1991 онд Монголд ардчилсан нийгэм тогтсоны үр дүнд улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн хүмүүсийн хэргийг цагаатгах "Цагаатгалын комисс" ажиллах болсноор 1993 оны 4-р сард Улсын дээд шүүхийн цэргийн коллегийн 88-р магадлалаар цагаатгажээ.

Төв аймгийн нутгаас энэ аймшигт хилсдүүлэлд нийт 65 тайж алагдсаны нэг нь Монгол улсын дипломатч, Шүүх яамны дэд сайд, Богд хааны шадар сайд Ц.Ширнэндамдин өртсөн нь Монгол улсын улс төрийн түүхэнд нэг орон зайг үлдээсэн юм.

Эцэст нь Ц.Ширнэндамдингийн улс төр, тусгаар тогтнолын талаар явуулсан үйл ажиллагааг дүгнэхэд тэрээр улс төрийн хувьд боловсорсон, туршлагатай дипломатч хүн байв. Тухайлбал, 1911-1912 оны ҮЭЧХ-ний үр дүнд Чин улсаас салж тусгаар улс болсноо хоёр их хөршөөр хүлээн зөвшөөрүүлэх их хэрэгт оролцож тодорхой үр дүнд хүрсэн. 1912 онд Хаант Орост албан ёсны айлчлал хийж, 1915 онд Орос, Хятадын хуйвалдааны дүнд 3 улсын гэрээ байгуулахад хүрэхэд Монгол улсын бүрэн эрх барих элчин төлөөлөгчөөр оролцож байв. Ингэхдээ өөрийн улсын байр суурийг бат хамгаалж тодорхой хэмжээний үр дүнд хүрч чадсан нь чамлахааргүй зүйл байв. Энэ бүх чармайлт үр дүнг нь үнэлж төрийн бэйлийн хэргэмээр шагнаж байлаа. Мөн 3 улсын хэлэлцээрт амжилттай оролцсон учир хойд, өмнөд хөршүүдээс түүнийг шагнаан урамшуулж байсан юм.

Ардын хувьсгалын ялалтын бэлтгэл хийгээд үр дүнд ялангуяа гадаад бодлогын асуудлаар Хятадын Бээжин хотноо удаа дараа очиж Жан Золин, Карахан зэрэг тухайн үеийн томоохон улс төрчидтэй уулзаж, Монгол улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэх, нийт Монгол үндэстнийг нэгтгэх туйлын зорилгоо хэрэгжүүлэхийн төлөө хүчин зүтгэж зохих үр дүнд хүрсэн билээ.

Ашигласан ном

1. Монгол улсын түүхийн төв архив
2. Тагнуулын Ерөнхий Газрын тусгай архив / Ф-1, Х/н-191/
3. Түшээт хан аймгийн Дархан чин ван Пунцагцэрэнгийн залгамжилсан уг эх /УТНС, гар бичмэл/
4. Идшинноров.С "Жинон ван Ширнэндамдин" /Буруугүй буруутнууд/ Зуунмод. 1993.
5. "Монгол улсын шастир". УБ.1997.
6. Лхамсүрэн.Б "Монголын гадаад орчин төрийн тусгаар тогтнол". УБ.1994.

7. Бат-Очир.Л. Отгонжаргал.С. "XX зууны монголын түүхэн үйл явц". УБ.1996.
8. "БНМАУ-ын түүх" II боть. УБ.1968.
9. "Монгол улсын түүх". УБ.1999.
10. "Хятад-Оросын харилцааны түүхэн дэх Монгол улс"/XX зуун/. УБ.1995.
11. Санжмятав.С. "3 улсын Хиагтын гэрээний тухай түүхэн үнэн"УБ.1991.
12. Магсаржав.Н. "Монголын шинэ түүх" УБ.1963.
13. Жамсран.Л. "Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлт". УБ.1997.
14. "БНМАУ-ын түүх" III боть. УБ.1984.
15. "Коминтерн ба Монгол". УБ.1996.
16. "Монгол Ардын Намын II их хурал ". УБ.1974.
17. Батсайхан.О "Монгол улсын хөгжлийн замд учирсан ээдрээ". УБ.1997.
18. "Монголын түүхийн хураангуй хэрэглүүн". /1924-1940 он/ УБ. 2000.
19. "Русско-китайские отношения" /1689-1916/ М.1958.
20. "Хятад, Орос, Монгол 3 улсын 1915 оны Хиагтын гэрээ" /өдөр тутмын тэмдэглэл/. УБ.1995.
21. Бор.Ж "Монголын улс төрийн гадаад бодлого, дипломатын уламжлалын зарим асуудал". УБ.1988.
22. Урангуа.Ж "XX зууны эхэн үе дэх Ар Монгол дахь шинэтгэл". УБ.1997.

The article deals with life long efforts of duke Ts. Shirnendamdin who served under Manchu Qing state to free and regain independence of Mongolia. He was one of the Mongolian noble aristocrats of progressive view of late 19th and early 20th century who honestly served to the Mongolian state becoming Deputy minister of Justice and later Deputy Prime Minister of Bogdo Khan's Government.